

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

Хөх далан хальсны суулгац. Техникийн шаардлага	MNS 6416 : 2013
Blue Honeysuckle seedlings. Technical requirement	

Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## 1 Хамрах ба хэрэглэх хүрээ

**1.1** Энэхүү стандарт нь Хөх далан хальс *Lonicera caerulea L.*-ны суулгацыг ногоон мөчрөөр болон үрээр үржүүлэх, бэлтгэн нийлүүлэх, чанарыг тогтоох, шалган хүлээн авах, багцлах, хадгалах, борлуулах, импортлох, тээвэрлэхэд хамаарна.

**1.2** Энэ стандартыг Хөх далан хальсны суулгацыг үржүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд, суулгац худалдан авагчид хэрэглэнэ.

**1.3** Энэхүү стандарт нь мөчир залгах, нахиа шигтгэх, үндэсний хэсгээр үржүүлсэн суулгацад хамаарахгүй.

## Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг эш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас эш татаж хэрэглэнэ.

- MNS 2782:79, Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Хортон шавьжийг илрүүлэх арга,
- MNS 4220:1994, Жигдийн тарьц, техникийн шаардлага,
- ГОСТ 13853:78, Яст болон үрт жимст модны үр, тариалалтын чанар. Техникийн нөхцөл,
- ГОСТ 24835:81, Интоорын, тарьц суулгац, тариалалтын чанар,
- MNS 6250:2011, Чацарганы суулгац, техникийн шаардлага,
- MNS 6251:2011, Үхэр нүдний суулгац, техникийн шаардлага,
- MNS 6370:2013 Интоорын суулгац, техникийн шаардлага,
- MNS 6373:2013 бөөрөлзгөний суулгац, техникийн шаардлага,
- GB 19174-200x, ICS 65.020.20 Кивины суулгацын стандарт,
- SNZ 155.02.06 Суулгац импортлох. Техникийн шаардлага.

## 3 Нэр томъёо, тодорхойлолт

### 3.1

#### хөх далан хальсны суулгац

эх цэцэрлэг байгуулахад зориулсан үржүүлгийн эх цэцэрлэгээс ногоон мөчрөөр гаргаж авсан 2 настай суулгац, үрээр үржүүлсэн 3 настай суулгац.

## **MNS 6416 : 2013**

### **3.2**

#### **жимст эх цэцэрлэг**

хөх далан хальсны жимс хурааж авах зориулалтаар байгуулсан талбай дахь цэвэр сортын бутны бүлгэмдэл,

### **3.3**

#### **үржүүлгийн эх цэцэрлэг**

мөчир авах зориулалтаар шигүүсгэн тариалсан, цэвэр сортын бутны бүлгэмдэл,

### **3.4**

#### **ургал эрхтний үржүүлэг**

үржүүлгийн эх цэцэрлэгийн бутнаас ногоон мөчир, нахиа үндэс зэргийн аль нэг хэсгээс авч үндэслүүлж суулгац гаргах арга,

### **3.5**

#### **үрийн үржүүлэг**

үрийг тарьж үндэслүүлэн суулгац гаргах арга,

### **3.6**

#### **ногоон мөчрийн суулгац**

үржүүлгийн зориулалтын эх цэцэрлэгээс тухайн жилийн өсөлтийн найлзуурыг моджиж хатуураагүй байхад нь мананжуулах төхөөрөмжинд үндэслүүлж дараа жил нь бойжуулж торинуулсан хоёр настай суулгац,

### **3.7**

#### **үрийн суулгац**

жимс авах зориулалттай эх цэцэрлэгээс бүрэн боловсорсон жимсийг хураан авч махлаг эднээс нь салган сүүдэр газар хатааж, хавар намар тарьж үндэслүүлэн дараа жил нь бойжуулж торниулсан 3 настай суулгац,

### **3.8**

#### **бойжуулгын талбай**

үр болон ургал эрхтнээр хүлэмжинд үндэслүүлсэн нэг наст тарьцыг суулгац болтол нь ургуулах тусгайлан бэлтгэсэн талбай,

### **3.9**

#### **үндэсний хүзүү**

бутны иш үндэс хоёрын зааг хэсэг,

### **3.10**

#### **механик гэмтэл**

мөчир нахиа хугарч бяцраагүй, үндэс тасраагүй, холтос шалбараагүй байдал,

### **3.11**

#### **амь чийг**

мөчир, үндэс хорчийж, ус чийг алдагдлын шинж ажиглагдаагүй байдал,

### **3.12**

#### **суулгацын өндөр**

үндэсний хүзүүнээс оройн хэсэг.

## 4 Ангилал

4.1 Хөх далан хальсны суулгацыг үржүүлсэн аргаас нь хамааруулж:

- Ногоон мөчрийн,
- Үрийн гэж ангилна.

4.2 Үндэсний систем болон газрын дээрх үндсэн салаа, мөчрийн морфологи шинж, чанарын үзүүлэлтээр нь:

- I дүгээр,
- II дугаар зэрэгт хуваана.

## 5 Техникийн шаардлага

5.1 Хөх далан хальсны суулгацыг баталсан тариалалтын технологийг баримтлан үржүүлнэ.

5.2 Хөх далан хальсны үржүүлгийн эх цэцэрлэгт сортын хянан баталгаа хийсэн байна.

5.3 Хөх далан хальсны суулгац нь сортын шинж чанараа бүрэн хадгалсан, бусад сортын хольцгүй байна.

5.4 Хөх далан хальсны жимслэх болон үржүүлгийн эх цэцэрлэг байгуулахад ногоон мөчрийн аргаар үржүүлсэн хоёр настай I, II-р зэргийн суулгацыг тариална.

5.5 Хөх далан хальсыг суулгацын чанар, гадаад шинж тэмдэгийн үзүүлэлтүүд 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

5.6 Суулгацын үндэс, мөчрийн гадаад байдал морфологи шинжийн үзүүлэлтийг 2-р хүснэгтэд зааснаар тодорхойлно.

### Хөх далан хальсны суулгацын чанарын үзүүлэлт

1-р хүснэгт

д/д	Үзүүлэлт	Чанарын шаардлага, зэрэг	
		I	II
1	Суулгацын гадаад байдал	Холтос нь бүтэн, сортын үндсэн өнгийг хадгалсан, иш нь бүдүүн, шулуун, нахиа нь, хэвийн, өвчин хортонд хөнөөгдөөгүй, үндэс нь ялзарч гэмтээгүй эрүүл байна.	
<b>Үндэсний систем</b>			
2	Үндэсний хүзүүний голч, см	0,4 см-ээс дээш	0,2 см-ээс дээш
3	Үндэсний салаалтын тоо, түүний урт, см	Урт нь 15 см-ээс дээш салаалалт нь 10-өөс цөөнгүй байна.	Урт нь 10 см-ээс дээш салаалалт нь 7-оос цөөнгүй байна.
<b>Газрын дээрх хэсэг</b>			
4	Суулгацын өндөр, см	30-60 см-ээс багагүй	20-30 см-ээс багагүй
5	Мөчрийн тоо	2-оос дээш	2 хүртэл

ТАЙЛБАР 1: Хөх далан хальсны II-р зэргийн шаардлагад хүрэхгүй суулгацыг мод үржүүлгийн газрын бойжуулгын талбайд тарина.

ТАЙЛБАР 2: Хадгалалт, тээвэрлэлтийн үед Хөх далан хальсны суулгацын нахиа ба холтос нь 10%-иас хэтрэхгүй механик гэмтэлтэй байхыг зөвшөөрнө.

## Морфологи шинжийн үзүүлэлт

2-р хүснэгт

д/д	Үзүүлэлт	Шинж тэмдэг
1	Үндэсний өнгө	Хүрэн
2	Үндэсний гадаад байдал	Үндсэн өнгө өөрчлөгдөж, харлаж ялзраагүй, хорчийж, хэрчлээ үүсээгүй, амь чийгтэй байна.
3	Мөчрийн гадаад байдал	Механик гэмтэл үндсэн салаа мөчрийн гадаргууд 10%-иас ихгүй байж болно.
4	Мөчрийн өнгө	Бор, хүрэн
5	Үндэс, мөчрийн эрүүл байдал	Хуурамч гуалалт /Pseudoperonospora sp/ болон бусад төрлийн өвчин хортон, шавьж, мэрэгч амьтанд хөнөөгдөөгүй байх.

**6 Дээж авах**

Суулгацын стандартын 1, 2-р хүснэгтэд заасан чанарыг баримтлан нийт суулгацын 10-аас доошгүй хувийг шалгаж хүлээн авна.

**7 Шалгах арга**

**7.1** Хөх далан хальсны суулгацыг хавар тарилт хийхээс өмнө буюу 4-р сарын 3 дугаар арав хоногт, намар тарихын өмнө 10-р сарын 2 дугаар арав хоногт багтаан шалгаж хүлээн авна.

**7.2** Суулгацын урт болон голчийг шугам ба штангенциркулиар хэмжинэ.

**7.3** Суулгацын өвчин хортон шавьжинд нэрвэгдсэн байдлыг MNS 2783:1979, “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, мөөгөнцөрийн өвчнийг илрүүлэх арга”, MNS 2784:2007 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, бактерийн гаралтай өвчнийг илрүүлэх арга” стандартуудын дагуу тус тус тодорхойлно.

**8 Багцлах, хаяглах****8.1 Суулгацын үндсийг боох**

Суулгацыг тээвэрлэхэд зориулан савлахдаа үндсийг гадны нөлөөнөөс бүрэн хамгаалах хэмжээний нийлэг хальс болон таар шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад, суулгацын үндсийг шороон зуурмагт хутгаж үзүүрийг нэг тийш нь харуулж тавиад суулгацыг өөр хоорондоо үрж холхихгүйгээр модны үртэс буюу шороогоор хөдөлгөөнгүй чигжисний дараа үндэсний хэсгийг битүүлэн ороож бооно.

**8.2** Багцалсан суулгацыг давхар тааран шуудайд савлана.

**8.3** Суулгацыг 50 буюу 100 ширхэгээр боож, хаягийг тээвэрлэлтийн үед тасарч гээгдэхээс хамгаалан боодлын гадна ба дотор талд зүүнэ.

а/ Боодлын дотор зүүх хаягийг 7 см урт, 5 см өргөн модон ба зузаан цаасаар хийж дээр нь зөвхөн сортын нэрийг бичнэ.

б/ Боодлын гадна зүүх хаягийг 10 см урт, 8 см өргөн хийж дээр нь сортын нэрийг, тоо ширхэг, зэрэг дугаарын хамт бичнэ. Хаягийг баларч арилахаас хамгаалсан байна.

**8.4** Багцалсан суулгацад дараах мэдээлэл бүхий шошго, зааврыг дагалдуулна.

- Суулгац үйлдвэрлэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр хаяг,
- Стандартын дугаар, тэмдэглэгээ,
- Сортын нэр,
- Хадгалах хугацаа нөхцөл,
- Тарьж ургуулсан он,
- Тарьж суулгах заавар.

## **9 Хадгалах**

**9.1** Мод үржүүлгийн газраас авсан суулгацыг тарих хүртэл түр хугацаагаар хадгалах тохиолдолд суулгацын үндэсний хэсгийг 15-аас 20 см зузаан чийгтэй шороогоор булж хадгална.

**9.2** Намар хүлээж авсан суулгацыг өвөлжүүлэх бол 30-аас 40 см гүн шанг салхины хөндлөн татаж суулгацыг шуудуунд хийж, салхины ноёлох зүгийн дагуу налуулж эгнүүлэн тавиад үндэсний хэсгийг 30-аас 40 см зузаан шороогоор булж ханатал усалж хадгална.

**9.3** Хадгалалтын хугацаанд мэрэгчид суулгацын үндсийг гэмтээхээс хамгаалж гүнзгий суваг татаж услах, эргэн тойрон хорт өгөөш тавих, нарийн тороор хаших ба цас ормогц хөрсний гадаргуу дээр ил байгаа суулгацын иш, мөчрийг цасаар нягтруулан дарна.

## **10 Тээвэрлэх**

**10.1** Багцалсан суулгацыг тээврийн хэрэгслийн тэвш, хашлага дотор тээвэрлэхдээ босоо байдлаар эгнүүлэн тавьж доор нь 10-аас 15 см зузаан зөөлөвч дэвсэж ачих бөгөөд боодлын хоорондох зай завсарт чийгтэй үртэсийг чигжиж дүүргэнэ. Хол тээвэрлэх тохиолдолд үндсийг тогтмол чийглэж хатахаас хамгаалах арга хэмжээ авна.

**10.2** Багцалсан суулгацыг нарны шууд тусгалаас хамгаалж сэрүүн нөхцөлд тээвэрлэнэ.

**10.3** Багцалсан суулгацыг хэт хүнд зүйлээр дарж бяцлах, уут задарч үндэс ил гарахаас сэрэмжлэх, шатах дэлбэрэх, бохирдуулах бодистой хамт тээвэрлэхийг хориглоно.

**10.4** Тээвэрлэлтийн нэг удаагийн үргэлжлэх хугацаа 4 хоногоос дээшгүй байна.

**ТӨГСӨВ.**